ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
1 ДҮГЭЭР СУРГУУЛЬ

# 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН




2024.06.20




**109 багш, ажилтан**

90 буюу 83% эм,
19 буюу 17% нь эр

**2544 сурагч**

1311 буюу 51% нь эм
1233 буюу 49% нь эр

Бага анги
1209 суралцагч
Дунд анги
880 суралцагч
Ахлах анги
455 суралцагч

## БАГШ НАРЫН МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ




| | | |
|---|---|---|
| Бакалавр | 52 | 67% |
| Магистр | 31 | 39.7% |

## БАГШ НАРЫН БОЛОВСРОЛЫН ЗЭРЭГ

# ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

04

“Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал”-ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх

03

Байгууллагын менежментийн төлөвлөлт, цэцэрлэг сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох

02

Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах

01

Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах

# ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

08

Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагааны арга хэмжээ

07

Байгууллагын орчны эрсдэлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж үр дүнг тооцох

06

Цэцэрлэг, сургууль дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлэх, сурах хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш ажилтан, эцэг эх асран хамгаалагч олон нийтийн оролцоо түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх, үр дүнг тооцох

05

Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагаа зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах

## НӨХӨН ХАНГАЛТЫН ЗАРДАЛ

50ш таблет



33ш chromebook



БШУЯ-аас хэрэгжүүлж буй "Боловсролын сургалтын байгууллагуудад утасгүй дотоод сүлжээ байгуулах" төслийн хүрээнд интернэт асуудал шийдвэрлэсэн



# “PEARSON” хөтөлбөрт 2023 -2024 оны хичээлийн жилд англи хэлний 8 багш 5-10 ангийн 1297 сурагчид хамрагдаж байна.

Бичих чадварын тодорхой сэдвийн хүрээнд  загвар дуурайлган бичих чадвар нэмэгдсэн.

Үгсийн сан сэдвийн хүрээнд үг, холбоо үгээр ангилах болон үгсийн аймгаар ялган таних  чадвар нэмэгдсэн.

Сонсох чадвар олон сонголтод  даалгавар нөхөх гүйцэтгэх  чадвар сайжирсан.




Платформ дээр ажиллах сурагчдын бие даан гүйцэтгэх чадварт ахиц гарсан .

Видео контент бичлэг үзсэнээр  сурагчдын  сонсоод ойлгох чадвар, үг сонголт практик хэрэглээ сайжирч байна.

Цаг баримтлах, хариуцлагатай байх, хувийн зохион байгуулалт хийх чадварт суралцаж байна.

# ЭДҮТЭН ЦАХИМ ПЛАТФОРМ

| III анги | IV анги |
|---|---|
| 4 багш | 4 багш |
| 233 суралцагч | 243 суралцагч |







Эдүтэн математикийн платформын хэрэгжилтийн сорилыг 12 сар болон 5 сард зохион байгуулсан. 3-р ангийн гүйцэтгэлийн хувь 5.7%, 4-р ангийн гүйцэтгэлийн хувь 10.8%-аар тус тус ахисан байна.

- **Хүүхэд бүр 1 таблет**
- **Анги бүр тв-тэй**
- **Ухаалаг дэлгэц**
- **Таблет байршуулах, цэнэглэх өрөөтэй**
- **Интернэтийн асуудал**

Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах






Х.Уранцэцэг
Хүүхдийн хөгжлийг
дэмжих танхимын
багш



Засварын ажил



Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим



Сургалтын хэрэглэгдэхүүн, төхөөрөмж

## ЗАСВАР ТОХИЖИЛТ, СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

**ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ**

**Нийт хөрөнгө оруулалт: 366,260,100 төгрөг**

Тоног төхөөрөмж туслах хэрэгсэл



Засвар үйлчилгээ



Хөгжлийн төв хэрэглэгдэхүүн



| | |
|---|---|
| Санхүүжүүлэгч байгууллага | Азийн Хөгжлийн Банк,<br>Цэцэглэн хөгжсөн, эрсдэлд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сан |

# Дорнод аймгийн 1 дүгээр сургууль 2023-2024 оны хичээлийн шинэ жилд тусгай ангиа хааж “ИНТЕГРАЦЧИЛСАН” сургуулиас “ТЭГШ ХАМРУУЛСАН” сургууль руу амжилттай шилжлээ.




1

**Үр дүн**

Тусгай ангийн 6 сурагчийг үе шаттай шилжүүлж тусгай ангиа хаасан

2

**Үр дүн**

Сурагч тус бүрт тодорхой хэмжээнд ахиц гарсан

3

**Үр дүн**

Ангийн бусад сурагчдад эерэг хандага нэмэгдсэн

4

**Үр дүн**

Багш эцэг эхийн уялдаа холбоо сайжирсан.

5

**Үр дүн**

Бусад сургуульд жишиг болсон














# ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТАНХИМ

(Хэрлэн сумын 1 дүгээр сургууль)



Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн I-VIII ангийн 17 сурагч ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байна.





Сургууль дундын загвар танхим болгон ашиглаж байна.



Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр ажиллаж буй багш нарт арга зүйн зөвлөгөө өгч байгаа нь



Хэрлэн сумын 5 дугаар сургуулийн I ангийн сурагч А.Эрдэмбилэг тохируулгат хэрэглэгдэхүүн ашиглан боловсролын үйлчилгээ авч байгаа нь



Хэрлэн сумын Хан-Уул цогцолбор сургуулийн сурагч Б.Энх-Энэрэл дохионы хэлний хичээл

“Бага ангийн багшийг дэмжих” төслийн хүрээнд бага ангийн багш Б.Отгонбилэг, бага ангийн сурагчдын ариун цэврийн өрөөний тохируулгат хэрэглэгдэхүүн, багш Ч.Батцагаан хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг сургуульд хамруулахад материаллаг болон сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэн 2 давхрын тохижилтыг хийж гүйцэтгэлээ.








ЗХУ-ЫН БААТАР Н.Ф.ГАСТЕЛЛОГИЙН НЭРЭМЖИТ ДОРНОД АЙМГИЙН 1-Р СУРГУУЛЬ
1923-2023



## Байгууллагын менежментийн төлөвлөлт, цэцэрлэг сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох

### Зорилт 1

- Судалгаат хичээл зохион байгуулах
- Бүтээлч даалгавар үйл ажиллагаа

### Зорилт 2

- “Номтой нөхөрлөе” үйл ажиллагаа
- Ардын өв соёлоос суралцъя
- Зөв хандлагаас- Зөв хүүхэд

### Зорилт 3

- “Анхаарч хамгаалъя” нөлөөллийн үйл ажиллагаа
- “Хариуцлагатай гэр бүл” үйл ажиллагаа

Үр дүн: Сургуулийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээр багшлахуй болон суралцахуйд тулгамдаж буй асуудлаа илрүүлж, сургуулийн менежментийн загварыг боловсруулан ажилласан. Сургуулийн менежментийн төлөвлөгөөнд тулгуурлан багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлгийн хамтын ажиллагаагаар хичээл, үйл ажиллагааг дэмжсэнээр сургалтын чанар, суралцагчдын хүмүүжил, төлөвшил, оролцоонд ахиц гарсан.

ЗХУ-ЫН БААТАР Н.Ф.ГАСТЕЛЛОГИЙН НЭРЭМЖИТ ДОРНОД АЙМГИЙН 1-Р СУРГУУЛЬ
1923-2023

## Байгууллагын менежментийн төлөвлөлт, цэцэрлэг сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох

Багш нар харилцан суралцах, хамтран хөгжих, багшлахуй болон суралцахуй, хүүхдийн хөгжил, сурах арга барил, сурлагын чанарт ахиц гаргах зорилгоор мэргэжлийн хөгжлийн бүлгээр нэгдэн ажиллаж байна.

- Арга зүйгээ хуваалцъя
- Номын ертөнц
- Ардын өв соёл
- Зөв хандлагаас-зөв хүүхэд
- Миний сургууль-Миний гэр
- Үндэсний бичгээ сурья
- Жаргалтай сэтгэл зүйг бүтээхүй
- Эцэг эх, асран хамгаалагчдыг дэмжихүй зэрэг 8 мэргэжлийн хөгжлийн бүлэг үйл ажиллагаа зохион байгуулж байна.









ЗХУ-ЫН БААТАР Н.Ф.ГАСТЕЛЛОГИЙН НЭРЭМЖИТ
ДОРНОД АЙМГИЙН 1-Р СУРГУУЛЬ
1923-2023

## "Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал"-ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх

1 дүгээр бүсийн сургуулиудын дунд зохион байгуулсан "ЗӨВЛӨХ БАГШИЙН МАНЛАЙЛАЛ-БҮСИЙН ЗӨВЛӨГӨӨН" үйл ажиллагааны хүрээнд МУ-ын зөвлөх багш Б.Туяа, Б.Болортуяа нар 11 дүгээр сургуулийн залуу багш Уганжаргал, Батцэцэг, Мөнхтуяа нарт математик, монгол хэл хичээлээр хүндэвтэр агуулгыг заах аргазүйн зөвлөгөө өгч, багш Мөнхтуяа, Батцэцэг нарын хичээлд сууж хичээлд суусан. Мөн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх талаар туршлагаа түгээн дэлгэрүүлэв. Тус үйл ажиллагаад 11, Flower сургуулиуд оролцлоо.











ЗХУ-ЫН БААТАР Н.Ф.ГАСТЕЛЛОГИЙН НЭРЭМЖИТ
ДОРНОД АЙМГИЙН 1-Р СУРГУУЛЬ
1923-2023

## “Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал”-ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх

“БАГШ СОЛИЛЦОО ХӨТӨЛБӨР”: Хэрлэн сумын 1-р бүсийн сургуулиудын “Багш солилцоо хөтөлбөр” 2024 оны 03 сарын 14-15-нд амжилттай явагдлаа.
1-р бүсийн /1, 11, Flower, Булган, Цагаан-Овоо ЕБС/ 5 сургуулийн 14 багш “Багш солилцоо хөтөлбөр”-т оролцлоо. Багш солилцоо хөтөлбөрийн хүрээнд багш нар судалгаат хичээл заах, хэлэлцүүлэг хийх, “Арга зүйгээ хуваалцъя” мэдээлэл солилцох уулзалт, ярилцлага зохион байгуулах, сургуулийн орчинтой танилцах зэрэг үйл ажиллагаанд хамрагдлаа.

Булган сумын сургуульд багш Б.Туяа, Ц.Алтансувд, С.Хэрлэнчимэг, Т.Сольчулуун нар 2 өдөр ажиллан “Арга зүйгээ хуваалцъя” хичээл, уулзалт ярилцлага зохион байгуулж сургуулийн орчинтой танилцах, спортын тэмцээнд оролцох зэрэг үйл ажиллагаанд оролцлоо.










## Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

Сургуулийн ёс зүйн дэд хорооны гишүүн, Монгол Улсын Зөвлөх багш Б.Туяа төрийн албан хаагчдад зориулсан "Ёс зүй ба түүний ойлголтууд" сэдвээр танхимын сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтыг явуулснаар багш нар төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, хэм хэмжээ, ёс зүйн хуулиар хүлээсэн үүрэг, хориглох зүйл хязгаарлалт, ёс суртахууны үнэт зүйл, үнэлэмж, ёс зүйтэй шийдвэр гаргалт яагаад чухал вэ? шийдвэр гаргалтын үр дагавар, ёс зүйн зөрчил, ёс зүйн хариуцлага, ёс зүйн гомдол мэдээллийг шалгахад баримтлах зарчим, түүнийг хэрхэн хянан шийдвэрлэх зэрэг төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийн талаарх мэдлэгээ дээшлүүлэв.






Ажлын эрчийг нэмэгдүүлж, уур амьсгалыг сайжруулахад хамт олны харилцаа чухал нөлөөтэй. Иймд бүхий л зүйлсэд хамтарч ажиллан, шийдлийг эрэлхийлж байх нь чухал учраас хамт олныхоо эерэг харилцаа хандлага, байгууллагын соёлыг дэмжиж түгээн дэлгэрүүлэх зорилгоор Мобикомын Дорнод салбарын захирал А.Тунгалагтуулыг урин “Эерэг хандлагыг түгээцгээе” уриан дор үйл ажиллагаа зохион байгууллаа. Багш нар алжаал ядаргаагаа тайлан цай уух зуур “Эерэг харилцаа хандлага, хандлагаа хэрхэн өөрчлөх” талаар сургалтад хамрагдан дасгал хөдөлгөөн хийн идэвхтэй оролцлоо. Уг үйл ажиллагаанд багш нар 100 хувь хамрагдлаа.

ЗХУ-ЫН БААТАР Н.Ф.ГАСТЕЛЛОГИЙН НЭРЭМЖИТ
ДОРНОД АЙМГИЙН 1-Р СУРГУУЛЬ
1923-2023

## Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд ээрэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

Тус хичээлийн жилд салбарын хууль, тушаал, тогтоол шийдвэрийн дагуу сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Багш ажилчдад:

“Хүүхдийн эрхийн тухай хууль, журам”

- “Боловсролын ерөнхий хууль”
- “Төрийн албан хаагчийн тухай хууль”
- “Хөдөлмөрийн тухай хууль”

4 төрлийн хуулийн сургалтыг байгууллагын 124 ажилтан 312 багш нарт зохион байгууллаа. /давхардсан тоогоор/ **Үр дүн:** Багш ажилчдын хууль эрх зүйн мэдлэг нэмэгдсэн.






Байгууллагын багш, ажилчдын эрүүл мэндийг дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, спортоор хичээллэх идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор волейболын тэмцээн зохион байгуулж, эхний 3 байрт шалгарсан багуудыг мөнгөн шагналаар шагнасан.

Цэцэрлэг, сургууль дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлэх, сурах хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш ажилтан, эцэг эх асран хамгаалагч олон нийтийн оролцоо түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх, үр дүнг тооцох



**Б.БАТСҮХ**
Захирал
багийн ахлагч



**Л.ХИШИГДЭЛГЭР**
Сургалтын менежер
багийн гишүүн



**Л.НАРАНЧИМЭГ**
Сургалтын менежер
багийн гишүүн



**Н.НАРАНТӨГС**
Сургалтын менежер
багийн гишүүн



**Б.БАТАА**
Нийгмийн ажилтан
багийн гишүүн



**П.ТУЯАМАА**
Нийгмийн ажилтан
Нарийн бичиг



**Г.ЦЭЦЭГЭЭ**
Эмч
багийн гишүүн



**Б.БОЛОРТУЯА**
Бага ангийн багш
багийн гишүүн



**М.МӨНХТУУЛ**
Англи хэлний багш
багийн гишүүн



**Т.ГАНТУЛГА**
Жижүүр
багийн гишүүн

# ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БАГ

# ТООН МЭДЭЭЛЭЛ

**17**
ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТ

**7**
ХАРИЛЦААНЫ ЗӨРЧИЛ

**12**
ЗӨРЧИЛ

**1**
ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ



# ТООН ҮЗҮҮЛЭЛТ

| № | Тоон үзүүлэлт | 2023-2024 он | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт тоо | Нас | | | Хүйс | |
| | | | 6-10 | 11-14 | 15-18 | Эр | Эм |
| 1 | Дотуур байранд амьдардаг хүүхдийн тоо | **0** | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2 | Тавиул хүүхдийн тоо | **88** | 29 | 30 | 29 | 31 | 57 |
| 3 | Хагас өнчин хүүхэд | **60** | 17 | 25 | 18 | 30 | 30 |
| 4 | Бүтэн өнчин хүүхэд | **5** | 0 | 2 | 3 | 2 | 3 |
| 5 | Сургууль завсардсан хүүхдийн тоо | **0** | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 6 | Малчин өрхийн хүүхдийн тоо | **190** | 86 | 60 | 44 | 89 | 101 |







## Аймгийн засаг даргын А/80 дугаар захирамж

## “ЭЦЭГ ЭХ ЗОХИЦУУЛАГЧ”

**Эцэг эх, асран хамгаалагчид өдөр бүрийн 07:30-08:10, 12:30-13:10, 17:00-17:30-18:10 цагуудад хуваарийн дагуу хүүхдийн аюулгүй байдал алдагдах, хэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, сурагчдыг сургуулийн орчинд байгаа замын хөдөлгөөнд аюулгүй оролцоход нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.**

2024.05 сарын 17-ны өдрийн байдлаар 60 бүлгийн 4188 эцэг эх асран хамгаалагч хамтран зохион байгуулсан байна.

**Эцэг эх, асран хамгаалагчтайгаа бүх сүлжээний дугаар руу үнэгүй ярих  боломжийг бүрдүүлсэн ИТГЭЛТЭЙ УТАС ажиллуулж эхлээд байна.**






# 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн сургуулийн сэтгэл зүйч ажиллаж байна.



**Б.НАРАНГАРАВ**
Сэтгэл зүйч

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/222 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуульд **"БОЛОВСРОЛЫН СЭТГЭЛ ЗҮЙЧ"**-ийг ажиллуулж эхэлсэн.

2023-2024 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 395 сэтгэл зүйч ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байна.



ЗХУ-ЫН БААТАР Н.Ф.ГАСТЕЛЛОГИЙН НЭРЭМЖИТ
ДОРНОД АЙМГИЙН 1-Р СУРГУУЛЬ
1923-2023

# СЭТГЭЛ ЗҮЙЧИЙН ЗӨВЛӨГӨӨ, ҮЙЛЧИЛГЭЭ

**01**

Хүүхдийн хөгжил, сэтгэл зүйн тулгамдсан асуудал, сэтгэц, зан үйлийн төлөв байдлыг үнэлэх, оношлох, дүгнэлт гаргах, эрсдлийн үнэлгээ хийх

364 суралцагч
50 эцэг эх

**02**

Хүүхдийн нийгэм сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, нөхөн сэргээх, анхан шатны сэтгэц заслын үйлчилгээ үзүүлэх

50 суралцагч
7 эцэг эх

**03**

Хүүхэд, багш, ажилтан, эцэг эхчүүд, асран хамгаалагчдад чиглэсэн хүүхдийн нийгэм сэтгэл зүйн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхүйц, сэтгэл зүйн боловсрол олгох сургалтын үйл ажиллагааг

1463 суралцагч
160 эцэг эх



# Байгууллагын орчны эрсдэлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж үр дүнг тооцох

Онцгой байдлын газрын албан хаагч нар суралцагчдад гамшгийн үеийн бэлэн байдал, газар хөдлөлтийн аюулаас хэрхэн өөрийгөө аврах талаар сургалтыг хийсэн.

Сургуулийн гадна болон дотоод орчны эрсдлийн үнэлгээг жилд 2 удаа хийсэн.

Сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан налуу зам дээр тэмдэг, тэмдэглэгээг шинээр будсан, мөн авто зогсоол дээр хөгжлийн бэрхшээлтэй хүний зогсоолын тэмдэглэгээг хийсэн.

Сургуулийн коридорын цахилгааны ил утсуудад дарлага хийж аюулгүй болгосон.

Галын багаж хэрэгсэл болон галын хорны тоог нэмэгдүүлж, гарцын тэмдэг, тэмдэглэгээг наасан.

Хөл бөмбөгийн талбайн хашааны салсан хэсгүүдийг гагнаж, бэхэлгээг хийсэн.

Бага сургуулийн ариун цэврийн өрөөнд тэргэнцэртэй хүүхдийн угаалтуурын тоноглол, мэдрэгчтэй холигч, хогийн сав болон ахлах болон бага сургуулийн авто машины зогсоол дээр стандартын тусгай тэмдэглэгээ, таних тэмдгийг хийж байршуулсан.

Сургуулийн орчинд хаягдсан байсан барилгын хог хаягдлыг цэвэрлэсэн. Мөн дутуу орхигдсон хүүхдэд аюултай байж болох илүү гарсан төмрүүдийг тасалж аюулгүй болгосон.

**Үр дүн:** Сургуулийн гадна, доторх эрсдэлийн үнэлгээг хийснээр 10 зөрчил илрүүлж хүүхдийн аюулгүй байдал алдагдахаас урьдчилан сэргийлсэн, орчин нөхцөл сайжирсан.

ЗХУ-ЫН БААТАР Н.Ф.ГАСТЕЛЛОГИЙН НЭРЭМЖИТ ДОРНОД АЙМГИЙН I-Р СУРГУУЛЬ
1923-2023

# Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагааны арга хэмжээ

Жил бүр үйлчилгээний ажилчдад зориулсан “Баярлалаа” үйл ажиллагааг зохион байгуулж, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэдэг. Энэ хичээлийн жилд сургуулийн үйлчлэгч 6 хүүхэдтэй өрх толгойлсон эх О.Алтангэрэлд сургуулийн багш нарын үйлдвэрчний эвлэлтэй хамтран гэрийн тавилга авч өгч тусламж үзүүллээ.

Манай сургууль эцэг эх асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Зочинтой өдөр” үйл ажиллагааг 2 дахь жилдээ хэрэгжүүлж байна. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлснээр эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо сайжрахаас гадна сурагчид ардын өв соёлоос суралцаж танин мэдэхүйн болон эрүүл аюулгүй амьдрах ухааны чадвар, мэдлэг ойлголт нэмэгддэг.



Монгол өв соёлоос суралцах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор I ангийн сурагчид “Дун”, II ангийн сурагчид “Нар сарны тохиол”, III ангийн сурагчид “Ингэ, ботго нийлүүлэх”, IV ангийн сурагчид “Гурван модон зангилаа”, V ангийн сурагчид “ Есөн түлхүүр” тоглоомыг сурч бага ангиа төгсөхөд хүүхэд бүр ардын 5 тоглоомыг сурч төгсдөг.

2023-2024 оны хичээлийн жилд суралцахуйд суурилсан мэргэжлийн хөгжлийн 8 бүлэг ажиллаж байна. Уг бүлгээр ажилласнаар багш нар багшлахуйд болон суралцахуйд тулгамдаж буй асуудлаа илрүүлэх, шийдвэрлэх арга замаа тодорхойлох, төлөвлөх хэрэгжүүлэх гарсан үр дүнгээ хуваалцах замаар хамтран хөгжиж, харилцан суралцах чадварт ахиц гарч байна.











100
ДОРНОД АЙМГИЙН 1-Р СУРГУУЛЬ
1923-2023

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД **БАЯРЛАЛАА**

